

# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Улаангом сумын 12-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/181/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М. Батсуурь
Улаанбаатар хот	Утас: 70453317 Цахим хаяг: batsuuriM@audit.gov.mn
2023 он	Аудитын менежер: М. Бат-Амгалан Утас: 70453799 Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
	Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Ариун төгс оршихуй Аудит" ХХК-ийн аудитор: Г.Баялаг
	Утас: 99023656 Цахим хаяг: <a href="mailto:ariuntuqsorshiuiaudit@gmail.com">ariuntuqsorshiuiaudit@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН 12-Р  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Б.ОДОНЧИМЭГ ТАНАА

2023.02.24 № ~~УБА~~ - 2023/181/НА - САА - ТЦЗ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын 12-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын 12-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200000106

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>71,829,585.00</b>	<b>98,726,510.42</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	19,013,780.42
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	19,013,780.42
3121	Төгрөг	00.00	19,013,780.42
31211	Төрийн сангийн харилцах	00.00	19,013,780.42
33	АВЛАГА	14,222,010.00	1,100,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	222,010.00	1,100,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	57,607,575.00	78,612,730.00
354	Хангамжийн материал	57,607,575.00	78,612,730.00
35460	Хүнсний материал	630,555.00	2,541,950.00
35470	Бусад хангамжийн материал	56,977,020.00	76,070,780.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,537,796,251.47</b>	<b>1,498,940,860.16</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,537,796,251.47	1,498,940,860.16
391	Газар	31,200,000.00	31,200,000.00
392	Биет хөрөнгө	1,506,596,251.47	1,467,740,860.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,508,875,362.00	1,508,875,362.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-53,985,834.18	-79,377,460.98
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,496,115.30	56,733,225.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,659,579.15	-27,963,196.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,609,823.84	31,109,623.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,044,636.34	-21,941,693.94
39217	Ном	305,000.00	305,000.00
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-880,000.00	-880,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,609,625,836.47</b>	<b>1,597,667,370.58</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,609,625,836.47</b>	<b>1,597,667,370.58</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,609,625,836.47	1,597,667,370.58
512	Хуримтлагдсан үр дүн	1,609,625,836.47	1,597,667,370.58
51210	Өмнөх үеийн үр дүн	1,609,625,836.47	1,609,625,836.47
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-11,958,465.89
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,609,625,836.47</b>	<b>1,597,667,370.58</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	505,902,640.89	487,932,970.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,407,455.68	5,587,670.00
120	Нийтлэг татварын бус орлого	91,407,455.68	5,587,670.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,458,493.68	1,940,510.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	83,875,362.00	1,427,800.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	73,600.00	2,219,360.00
	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>414,495,185.21</b>	<b>482,345,300.00</b>
	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>380,456,300.00</b>	<b>416,684,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	380,456,300.00	416,684,800.00
	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>34,038,885.21</b>	<b>65,660,500.00</b>
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,038,885.21	65,660,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>425,342,145.07</b>	<b>499,891,435.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>425,342,145.07</b>	<b>499,891,435.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>416,115,686.80</b>	<b>499,678,250.13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>277,782,217.23</b>	<b>314,912,951.01</b>
210101	Үндсэн цалин	237,200,039.23	242,543,765.72
210102	Нэмэгдэл	15,769,223.00	52,223,352.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,314,218.50
210104	Урамшуулал	24,812,955.00	18,831,614.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>38,500,543.50</b>	<b>38,764,996.67</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,280,686.78	26,224,115.76
210202	Тэтгэмжийн даатгал	2,805,732.20	3,109,344.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,242,635.29	2,344,167.85
210204	Ажилгүйдлийн даатгал	560,440.97	1,290,897.52
210205	Эрүүл мэндийн даатгал	5,611,048.26	5,796,470.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,438,885.21</b>	<b>39,938,746.14</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,659,215.21	7,821,716.14
210302	Түлш, халаалт	22,096,570.00	30,922,430.00
210303	Цэвэр, бохир ус	1,683,100.00	1,194,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,947,503.68</b>	<b>1,907,400.00</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,338,000.00	1,907,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>13,253,945.00</b>	<b>51,519,655.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	85,000.00	146,250.00
210502	Хоол, хүнс	13,112,945.00	51,373,405.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>300,000.00</b>	<b>300,000.00</b>
210604	Урсгал засвар	300,000.00	300,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,568,900.00</b>	<b>699,900.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,136,900.00	699,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,977,692.18</b>	<b>51,634,601.31</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	5,587,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,906,400.00	4,455,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,071,292.18	41,592,301.31
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,226,458.27</b>	<b>213,185.76</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,426,458.27</b>	<b>213,185.76</b>

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,426,458.27	213,185.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>80,560,495.82</u>	<u>-11,958,465.89</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>80,560,495.82</u>	<u>-11,958,465.89</u>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>414,495,185.21</b>	<b>482,345,300.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>414,495,185.21</b>	<b>482,345,300.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>380,456,300.00</b>	<b>416,684,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	380,456,300.00	416,684,500.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>34,038,885.21</b>	<b>65,660,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,038,885.21	65,660,500.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>414,495,185.21</b>	<b>463,331,519.58</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>414,495,185.21</b>	<b>463,331,519.58</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>405,298,726.94</b>	<b>463,118,333.82</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>276,232,763.67</b>	<b>316,030,343.22</b>
210101	Үндсэн цалин	234,002,937.67	241,586,363.24
210102	Нэмэгдэл	17,416,883.00	54,274,300.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,317,799.50
210104	Урамшуулал	24,812,943.00	18,851,879.60
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,873,478.06</b>	<b>38,525,594.46</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,653,617.34	25,419,148.03
210202	Тэтгэмжийн даатгал	2,805,736.20	3,674,910.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,242,635.29	2,490,391.90
210204	Ажилгүйдлийн даатгал	560,440.97	1,290,897.61
210205	Эрүүл мэндийн даатгал	5,611,048.26	5,650,246.60
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,438,885.21</b>	<b>39,938,746.14</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,659,215.21	7,821,716.14
210302	Түлш, халаалт	22,096,570.00	30,922,430.00
210303	Цэвэр, бохир ус	2,683,100.00	1,194,600.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>14,637,900.00</b>	<b>53,284,800.00</b>
210502	Хоол, хүнс	13,743,500.00	53,284,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,000,000.00</b>	<b>300,000.00</b>
210604	Урсгал засвар	600,000.00	300,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,568,900.00</b>	<b>699,900.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,136,900.00	699,900.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,045,100.00</b>	<b>14,338,950.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	9,883,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,045,100.00	4,455,000.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,196,458.27	213,185.76
2133	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,426,458.27	213,185.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,426,458.27	213,185.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	19,013,780.42
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	19,013,780.42
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	19,013,780.42

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2022 оны 01-р сарын 01-рх үлдэгдэл	00.00	00.00	1,609,625,836.47	1,609,625,836.47
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	1,609,625,836.47	1,609,625,836.47
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн есөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,958,465.89	-11,958,465.89
D09	2022оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	00.00	00.00	1,597,667,370.58	1,597,667,370.58

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	416,684,800.00	397,671,019.58	19,013,780.42	-	95.4%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	416,684,800.00	397,671,019.58	19,013,780.42	-	95.4%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,684,800.00	397,671,019.58	19,013,780.42	-	95.4%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	294,546,100.00	293,620,472.22	-925,627.78	-	99.6%
210101	Үндсэн цалин	240,311,900.00	223,474,485.24	16,837,414.76	-	93.0%
210102	Нэмэгдэл	50,252,600.00	51,823,640.88	1,571,040.88	-	103.0%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,157,399.50	1,157,399.50	-	0.0%
210104	Урамшуулал	3,981,600.00	17,164,946.00	13,183,346.00	-	431.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,914,800.00	35,726,897.36	11,187,902.64	-	76.1%
210201	Тэтгэврийн даатгал	31,895,000.00	23,521,350.93	-7,808,083.55	-	75.5%
210202	Тэтгэмжийн даатгал	3,755,200.00	3,450,010.32	-870,755.20	-	76.8%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,003,800.00	2,310,191.90	-693,608.10	-	76.9%
210204	Ажилгүйдлийн даатгал	750,600.00	1,245,797.61	495,197.61	-	165.9%
210205	Эрүүл мэндийн даатгал	7,510,200.00	5,199,546.60	-2,310,653.40	-	69.2%
2105	Нормативт зардал	59,743,900.00	53,284,800.00	-6,459,100.00	-	89.0%
210502	Хоол, хүнс	59,743,900.00	53,284,800.00	-6,459,100.00	-	89.0%
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	962,000.00	699,900.00	262,100.00	-	
	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.00	699,900.00	262,100.00	-	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,518,000.00	14,338,950.00	-179,050.00	-	98.7%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,018,000.00	9,883,950.00	-134,050.00	-	98.6%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	4,455,000.00	-45,000.00	-	99.0%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	416,684,800.00	416,684,800.00			
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	416,684,800.00	416,684,800.00			
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих					

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	19,013,780.42		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00		
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00		
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00		
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	00.00	01.00		

## 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,660,500.00	65,447,314.24	213,185.76	99.7%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,660,500.00	65,447,314.24	213,185.76	99.7%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,660,500.00	65,447,314.24	213,185.76	99.7%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,530,000.00	22,409,871.00	120,129.00	99.5%
210101	Үндсэн цалин	22,530,000.00	18,210,659.00	4,319,341.00	80.1%
210102	Нэмэгдэл	0	2,450,660.00	-2,450,660.00	0.0%
210104	Урамшуулал	0	1,748,552.00	-1,748,552.00	0.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,816,500.00	2,798,697.10	17,802.90	99.4%
210201	Тэтгэврийн даатгал	1,915,200.00	1,897,797.10	17,402.90	99.1%
210202	Тэтгэмжийн даатгал	225,200.00	224,900.00	300.00	99.9%
210203	ҮОМШӨ-ний даатгал	180,300.00	180,200.00	100.00	99.9%
210204	Ажилгүйдлийн даатгал	45,100.00	45,100.00	0.00	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	450,700.00	450,700.00	0.00	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,014,000.00	39,938,746.14	75,253.86	99.8%
210301	Гэрэл, цахилгаан	12,000,000.00	7,821,716.14	4,178,283.86	65.2%
210302	Түлш, халаалт	24,969,000.00	30,922,430.00	-5,953,430.00	123.8%
210303	Цэвэр, бохир ус	3,045,000.00	1,194,600.00	1,850,400.00	39.2%

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	300,000.00		
210604	Урсгал засвар	300,000.00	300,000.00		
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,660,500.00	65,447,314.24	213,185.76	99.7%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	65,660,500.00	65,447,314.24	213,185.76	99.7%
320001	Орон нутгийн төсвөөс	65,660,500.00	65,447,314.24	213,185.76	99.7%

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын 12-р цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Тайлант онд тус цэцэрлэг нь “Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, хүүхэд сурах, хөгжих тэгш боломжийг бүрдүүлэн сургалтын чанар, үр дүнд ахиц гаргана” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Улаангом сумын 12-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Улаангом сумын 12-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,958.4 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.00	19,013.8	19,013.8
Авлага	14,222.0	1,100.0	-13,122.0
Бараа материал	57,607.6	78,612.7	21,005.1
Үндсэн хөрөнгө	1,537,796.2	1,498,940.9	-38,855.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,609,625.8</b>	<b>1,597,667.4</b>	<b>-11,958.4</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,609,625.8	1,597,667.4	-11,958.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,609,625.8</b>	<b>1,597,667.4</b>	<b>-11,958.4</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 19,013.8 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 1,100.0 мянган төгрөг болж 13,122.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд ковидын нөхцөл байдалтай холбоотой 2021 оны 12-р сарын 31-нд хөрөнгө хүлээн зөвшөөрөлтийн шалгуур бүрэн хангаагүй байсан учир шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг байгууллагаас авах авлагаар бүртгэсэн байна. Харин 2022 онд хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуурт бүрэн нийцсэн учир авлагыг 14,000.0 мянган төгрөгөөр бууруулсан нь зонхилж нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 78,612.7 мянган төгрөг болж 21,005.1 мянган төгрөгөөр байна. Энэхүү өсөлтөд Шимт боловсролын байгууллагаас нийлүүлсэн 14,000.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материалаар ангилан бүртгэсэн сургалтын хэрэглэгдэхүүний үнэ зонхилж нөлөөлсөн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,498,940.9 мянган төгрөг болж 38,855.3 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд 2,736.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил хандиваар хүлээн авсан, тайлант хугацааны элэгдлийн зардлаар 41,592.3 мянган төгрөг тооцсон байна.

Тайлант оны эцэст өр төлбөр байхгүй байна. Харилцагч байгууллагуудтай холбоотой өр төлбөр нь тооцооны үлдэгдлээр баталгаажсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,597,667.4 мянган төгрөг болж 11,958.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 642,917.1 мянга, орон нутгийн төсвөөс 65,660.5 мянган төгрөг нийт 708,577.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 226,232.3 мянган төгрөгийг бууруулж 482,345.3 мянган төгрөгийг баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байдлаас шалтгаалсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 416,684.8 мянга, орон нутгийн төсвөөс 65,660.5 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 416,684.8 мянга, орон нутгийн төсвөөс 65,660.5 мянган төгрөг, нийт 482,345.3 мянган төгрөгийн төсвийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 463,118.3 мянган төгрөг буюу 96 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 19,227.0 мянган төгрөгөөр хэмнэж ажилласантай холбоотой байна. Тайлант онд 213.2 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Улсын төсөв	416,684.8	397,671.0	19,013.8	95.4%
2	Орон нутгийн төсөв	65,660.5	65,447.3	213,2	99.6%
	Нийт	482,345.3	463,118.3	19,227.0	96%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Улаангом сумын 12-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ариун төгс оршихуй Аудит” ХХК-ийн аудитор Г.Баялаг, гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлэн ажиллаа.

Увс аймгийн Улаангом сумын 12-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ариун төгс оршихуй аудит” ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2022 оны санхүүгийн тайлан бүрэн тайлагнагдаагүй байсан тул 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 414,265.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 4,142.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 499,891.4 мянган төгрөгийн 1 хувь буюу 4,998.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 3,999.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Увс аймгийн Улаангом сумын 12-р цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлогыг нарийвчлан тусгагдаагүйгээс үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа нь харилцан адилгүй ялгаатай байна.

Үүнтэй холбоотой байгууллагын одоогийн мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөн найруулж, шинэчлэх шаардлагатай байна.

Тус цэцэрлэг нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Тайлант хугацаанд 201,004.9 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс 169,283.8 мянган төгрөгийн худалдан авалт И-баримтаар баталгаажаагүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс аймгийн Улаангом сумын 12-р цэцэрлэгийн хувьд дараагийн аудитаар И-баримтаар баталгаажсан худалдан авалт хийж буй эсэхэд анхаарах.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЫ

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

БЭЛТГЭСЭН:

"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ"  
ХХК-ийн АУДИТОР

Г.БАЯЛАГ

2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

